



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны үйл ажиллагаа, санхүүжилтийн журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Б.ЖАВХЛАН

9763000294

Сангийн сайдын 2025 оны 03 дугаар
сарын 28 -ны өдрийн 59 дүгээр
тушаалын хавсралт

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хороо /цаашид “хороо” гэх/-ны үйл ажиллагаа, санхүүжилттэй холбогдох харилцааг зохицуулна.

Хоёр. Хорооны чиг үүрэг

2.1. Хороо нь дараах чиг үүрэгтэй:

2.1.1. Санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох бүртгэлийн, аудитын, үнэлгээний, мэргэжлийн нягтлан бодогчдын тасралтгүй боловсролын, ёс зүйн гэсэн олон улсын стандартын орчуулгыг хянан, батлах;

2.1.2. Санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох бүртгэлийн, аудитын, үнэлгээний, мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн үндэсний стандартын төслийг хянан, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах;

2.1.3. Нягтлан бодох бүртгэл, аудит, үнэлгээний заавар, журам, аргачлал, маягтын төслийг холбогдох стандартад нийцэж буй эсэхийг хянан, батлуулахаар Сангийн сайдад хүргүүлэх;

2.1.4. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн, аудитын, үнэлгээний олон улсын болон үндэсний стандартын тайлбар, хэрэглээний зөвлөмжийг батлах;

2.1.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг дагаж мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагад стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр санал боловсруулж, Сангийн сайдад хүргүүлэх;

2.1.6. Санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох бүртгэл, аудитын, үнэлгээний олон улсын стандартын хэрэглээ, нэвтрэлтийн асуудлаар санал боловсруулж, Сангийн сайдад хүргүүлэх;

2.1.7. Аудитын тухай хуулийн 15.1.4 болон 16.4-т заасан асуудлаар хороонд хандсан тохиолдолд мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.8. Аудитын болон хөрөнгийн үнэлгээний хуулийн этгээдэд хийсэн чанарын хяналтын үр дүн, нэгдсэн дүгнэлттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд хуралдаанаар хэлэлцэж, холбогдох дүгнэлтийг Сангийн сайдад хүргүүлэх;

2.1.9. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрх сунгах шалгалтын тестийн агуулга нь холбогдох олон улсын стандартад нийцэж буй эсэхэд 2 жил тутамд зөвлөмж гаргах;

2.1.10. Олон улсын болон бүс нутаг, гадаад орны холбогдох байгууллагаас зохиогдох арга хэмжээнд эрхэлсэн асуудлынхаа хүрээнд оролцох, хандивлагчид болон бусад байгууллагын санхүүгийн дэмжлэг авах замаар төсөл хэрэгжүүлэх.

Гурав. Хорооны гишүүдийг сонгох, томилох, чөлөөлөх

3.1. Хороо нь дараах байгууллагын төлөөлөл бүхий 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

3.1.1.Хорооны дарга

3.1.1.1. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

3.1.2.Хорооны гишүүн бөгөөд нарийн бичгийн дарга

3.1.2.1. Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын нягтлан бодох бүртгэлийн стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн

3.1.3.Хорооны гишүүн

3.1.3.1. Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга

3.1.3.2. Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга

3.1.3.3. Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ-ны асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл-1

3.1.3.4. Үндэсний аудитын газрын санхүү, нийцлийн аудитын асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл-1

3.1.3.5. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын төлөөлөл-1

3.1.3.6. Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөл-1

3.1.3.7. Нягтлан бодох бүртгэл, үнэлгээний чиглэлийн мэргэжлийн их, дээд сургуулийн төлөөлөл -2

3.1.3.8. Аудитын хуулийн этгээдийн төлөөлөл (олон улсын сүлжээ аудитын хуулийн этгээдээс-1, бусад аудитын хуулийн этгээдээс-1) -2

3.1.3.9. Нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл-1

3.1.3.10. Стандарт, хэмжил зүйн газрын стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл-1

3.1.3.11. Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн төлөөлөл-1

3.2. Энэ журмын 3.1.2.1, 3.1.3.1-3.1.3.9-т заасан гишүүн нь дараах шалгуурыг хангасан байна:

3.2.1. Монгол Улсын эсхүл олон улсын мэргэшсэн нягтлан бодогч байх;

3.2.2. Мэргэжлийн англи хэлний өндөр түвшний мэдлэгтэй байх;

3.2.3. Төрийн байгууллагын төлөөлөл нь ахлах мэргэжилтэн, ахлах аудитор болон түүнээс дээш албан тушаалд ажилладаг байх;

3.2.4. Аудитын хуулийн этгээдийн төлөөлөл нь аудитын хуулийн этгээдэд аудитын менежер болон түүнээс дээш албан тушаалд ажилладаг байх;

3.2.5. Их, дээд сургуулийн төлөөлөл нь нягтлан бодох бүртгэл, үнэлгээний чиглэлийн мэргэжлийн хичээл заадаг үндсэн орон тооны багш байх;

3.2.6. Нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан стандартыг дагаж мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагад ерөнхий нягтлан бодогч эсхүл санхүү эрхэлсэн захирал, тэдгээртэй адилтгах албан тушаалд ажилладаг байх.

3.3. Журмын 3.1.3.3-3.1.3.7, 3.1.3.10, 3.1.3.11-д заасан төлөөллийг сонгохдоо албан тушаалтныг санал болгон ирүүлэх талаар холбогдох байгууллагад Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газраас албан бичгээр мэдэгдэнэ.

3.4. Журмын 3.1.3.8, 3.1.3.9-д заасан төлөөллийг сонгохдоо Сангийн яамны болон холбогдох байгууллагын цахим хуудсаар дамжуулан нээлттэй зар хүргүүлнэ.

3.5. Тухайн байгууллага нь төлөөллөө хорооны гишүүнд нэр дэвшүүлэхээр санал болгохдоо 2-оос доошгүй нэр дэвшигчийн тодорхойлолтыг журмын 3.2-т заасан шалгуур, шаардлагыг хангаж буйг нотлох баримт болон анкетын хамт Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт ирүүлнэ.

3.6. Журмын 3.1-д заасан байгууллагаас санал болгосон нэр дэвшигч нь энэ журмын 3.2-т заасан шалгуур, шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд шалгуурыг хангах нэр дэвшигчийг дахин санал болгож болно.

3.7. Хорооны нарийн бичгийн дарга нь журмын 3.5-д заасны дагуу материалаа ирүүлсэн нэр дэвшигчдийг хорооны даргад танилцуулж, гишүүдийг сонгоно.

3.8. Сангийн сайд хорооны дарга, гишүүдийг 3 жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.

3.9. Хорооны дарга гишүүдийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх талаар Сангийн сайдад танилцуулж, шийдвэрлүүлнэ:

3.9.1. Хороонд гишүүнээ томилуулсан байгууллага төлөөллийн байдал хангагдахгүй байна гэж үзээд төлөөлөгчөө татаж, өөр нэр дэвшигчийг гишүүнээр томилуулах саналаа ирүүлсэн;

3.9.2. Хорооны ажилд оролцдоггүй, хурлын шийдвэрийг удаа дараа биелүүлээгүй;

3.9.3. Хүндэтгэх шалтгаангүйгээр хорооны хуралдаанд хоёроос дээш удаа оролцоогүй;

3.9.4. Эрүүл мэндийн шалтгааны улмаас, эсхүл хувийн хүндэтгэн үзэх зайлшгүй шаардлагаар ажил үүргийг цаашид гүйцэтгэх боломжгүй болсон;

3.9.5. Хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйг зөрчсөн нь тогтоогдсон.

Дөрөв. Стандарт, журам, аргачлал, зааврыг хянах

4.1. Хорооны нарийн бичгийн дарга нь Институт болон үнэлгээний мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн стандарт, тайлбар, зөвлөмжийг хянуулахаар гишүүдийг ажлын хэсэгт хуваарилж, хорооны даргад танилцуулна.

4.2. Ажлын хэсгийг Стандартын хорооны дарга таваас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй томилж, удирдамжийг батална.

4.3. Ажлын хэсгийн удирдамжид ажлын хэсгийн ахлагч, гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүрэг, хянах ажиллагаа, дуусгах хугацааг заасан байна.

4.4. Ажлын хэсэг дүгнэлтээ удирдамжид заасан хугацаанд хорооны хуралдаанд танилцуулах үүрэгтэй.

4.5. Ажлын хэсгийн дүгнэлт нь дараах хэлбэртэй байна:

4.5.1. Орчуулсан, боловсруулсан стандарт, тайлбар, зөвлөмж нь шаардлага хангасан;

4.5.2. Орчуулсан, боловсруулсан стандарт, тайлбар, зөвлөмжийг ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу засаж, сайжруулсан тохиолдолд шаардлага хангах боломжтой;

4.5.3. Орчуулсан, боловсруулсан стандарт, тайлбар, зөвлөмж нь шаардлага хангаагүй, дахин боловсруулах шаардлагатай.

4.5. Ажлын хэсэг энэ журмын 4.5.1-д заасан дүгнэлт гаргасан тохиолдолд орчуулсан, боловсруулсан стандарт, тайлбар, зөвлөмжийг Стандартын хорооны хурлаар хэлэлцэнэ.

4.6. Стандартын хороо орчуулсан, боловсруулсан стандарт, тайлбар, зөвлөмжийг шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд дараах этгээдэд батлуулахаар хүргүүлнэ:

4.6.1 Санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох бүртгэлийн, аудитын, үнэлгээний, мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад;

4.6.2. Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан стандарт, заавар, журам, зөвлөмжийг Сангийн сайдад.

4.7. Ажлын хэсэг энэ журмын 4.5.2 болон 4.5.3-т заасан дүгнэлт гаргасан бол дахин боловсруулахаар Институт болон үнэлгээний мэргэжлийн байгууллагад буцаана.

Тав. Хорооны хуралдаан

5.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

5.2. Хорооны хурлын ирцийг гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

5.3. Хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаарх шийдвэрийг гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөрт тооцно. Хэрэв санал тэнцвэл хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

5.4. Хорооны гишүүн хүндэтгэх шалтгаанаар тухайн хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд саналаа урьдчилан бичгээр ирүүлнэ.

5.5. Хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Хорооны дарга, эсхүл гурваас цөөнгүй гишүүний саналаар нэмэлт хуралдааныг зарлан хуралдуулж болно.

5.6. Хороо нь өөрийн хэлэлцэж буй асуудлын хүрээнд мэргэжлийн хөндлөнгийн шинжээчийг оролцуулж болно.

5.7. Хорооны даргын эзгүйд түүний томилсон гишүүн хуралдааныг даргална.

5.8. Нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн танилцуулах, хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах, хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг хорооны даргаар батлуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдааны зарыг хуралдаанаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө хүргэх зэрэг асуудлыг хариуцна.

5.9. Хорооны гишүүд хуралдаанаар хэлэлцэх асуудлын төсөл, материалтай урьдчилан танилцаж, мөрдөж буй хууль тогтоомж, стандарттай нийцсэн эсэх талаарх санал дүгнэлтээ бэлтгэн хуралдаанд оролцоно.

5.10. Хорооны хуралдаанаар аль нэг гишүүний хувьд ашиг сонирхлын зөрчил бүхий асуудлыг хэлэлцэх үед тухайн гишүүн энэ тухайгаа хуралдаан даргалагчид мэдэгдэх бөгөөд уг асуудлыг хэлэлцэж эхлэх үед хуралдаанаас гарч, шийдвэр гаргах санал хураалт явагдсаны дараа хуралдаанд оролцоно.

5.11. Хорооны гишүүн аль нэг асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй талаар мэдэгдэлгүй шийдвэр гаргахад оролцсон тохиолдолд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Хорооны шийдвэр

6.1. Хорооны хуралдааны шийдвэр нь тогтоол, хурлын тэмдэглэл хэлбэртэй байна.

6.2. Хорооны хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд хурлын шийдвэрийг ажлын 5 өдрийн дотор албажуулна.

6.3. Хорооны тогтоолд дарга, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.

6.4. Хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийн талаар Сангийн яамны цахим хуудсанд байрлуулах болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ.

6.5. Хуралдааны явцын албажуулсан тэмдэглэл, тогтоолыг Сангийн яамны архивд хадгална.

Долоо. Хорооны санхүүжилт

7.1. Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлын төсвийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Сангийн яамны жил бүрийн төсөвт тусгуулна.

7.2. Хорооны төсвийг гишүүдийн хууль, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

7.3. Хорооны үйл ажиллагааны болон санхүү, төсвийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.